



**МОНГОЛ УЛСЫН  
ДЭЭД ШҮҮХ**

**УЛСЫН ДЭЭД ШҮҮХ  
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН  
2016 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

**Улаанбаатар хот  
2016 он**



## ГАРЧИГ

|  |       |
|--|-------|
| 1. Илтгэгчийн үг: Ерөнхий шүүгч Ц.Зориг                          | 1-2   |
| 2. Шүүгч, ажилтнуудын бүтээл                                     | 3     |
| 3. Улсын Дээд шүүхийн 2016 оны ажлын тайлангийн товч танилцуулга | 4-5   |
| 4. Эрүүгийн хэргийн танхимын шүүн таслах ажлын тайлан            | 6-10  |
| 5. Иргэний хэргийн танхимын шүүн таслах ажлын тайлан             | 11-16 |
| 6. Захиргааны хэргийн танхимын шүүн таслах ажлын тайлан          | 17-21 |
| 7. Бусад асуудлаар...  | 22-24 |
| 8. Тамгын газрын ажлын тайлан                                    |       |
| 9. Захиргаа удирдлагын хэлтсийн ажлын тайлан                     | 25-28 |
| 10. Шүүхийн практик судлалын хэлтсийн ажлын тайлан               | 28-30 |
| 11. Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн ажлын тайлан           | 30-33 |
| 12. Шүүхийн зохион байгуулалтын хэлтсийн ажлын тайлан            | 33-34 |
| 13. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн ажлын тайлан | 34-35 |
| 14. Ерөнхий шүүгчийн ажлын албаны ажлын тайлан                   | 36-37 |
| 15. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны ажлын тайлан      | 37-39 |
| 16. Дотоод аудитын албаны ажлын тайлан                           | 39-41 |
| 17. Сургалт семинар  | 41-48 |



## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ, ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2016 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

*Илтгэгч: Ерөнхий шүүгч Ц.Зориг*

Эрхэм шүүгч, ажилтнуудаа!

Өнгөрч буй 2016 онд Монгол Улсад орчин цагийн шүүх байгуулагдсаны 105, Монгол Улсын Дээд шүүх байгуулагдсаны 90 жилийн түүхт ойг тэмдэглэн өнгөрүүлэх, мөн шүүхийн шинэчлэл, шүүн таслах ажиллагааны чанар болон шүүхийн захиргааны удирдлагын шинэ бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг анхааран ажилласан нэн хариуцлагатай, түүхэн жил болж өнгөрлөө.

Ойн хүрээнд зарим арга хэмжээг ёслол төгөлдөр тэмдэглэж, орчин цагийн шүүхийн үйл ажиллагаа, төлөвшилт, хийж бүтээсэн ажлын үр дүн, ололт амжилт, алдаа дутагдлыг дүгнэсэн онцлог жил болсныг дурдах нь зүйтэй.

Түүнчлэн дээрх ажлын хүрээнд “**Монголын шүүх**” 3 боть номыг хэвлэн нийтлүүлж, олны хүртээл болгосноос гадна анх удаагаа бүх шатны шүүхүүдийн баг, тамирчид оролцсон “**Шүүхийн спортын их наадам-2016**” тэмцээнийг амжилттай зохион байгуулсан нь онцлог байлаа.

Мөн эрх зүйт төрийн нэг шалгуур болсон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарчмын өөрчлөлт гарлаа. Захиргааны Ерөнхий хуулийг Монгол Улсад анх удаа баталж, түүний процессийн хуулийг шинэчлэн найруулж баталлаа.

Одоо бидэнд тэдгээр хуулийн хэрэгжилтийг нэг мөр хэрэгжүүлэх бодлогын зорилтууд хүлээгдэж байна.

Энэ хугацаанд шүүхийн гадаад харилцааг өргөжүүлэх, харилцан найрсаг хамтын ажиллагааг бэхжүүлэх, гадаадын зарим орнуудтай хамтран зохион байгуулж буй шүүгчдийн сургалтыг тогтмолжуулах, түүний үр нөлөөг дээшлүүлэх, тодорхой зарим арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлснээр БНХАУ, БНСУ, Испанийн сургалтууд тогтмолжихийн зэрэгцээ олон улсын гишүүнчлэл бүхий шүүх, бусад байгууллага, нэгдэлүүдтэй хамтран ажиллах эхлэлийг тавьлаа.

Тулгар төрийн 2225 жил, Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 95 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг буулган Улсын Дээд шүүхийн шүүгч **Х.Батсүрэн**, Шүүхийн практик судлалын хэлтсийн дарга **Ч.Нямсүрэн** нарыг “Хөдөлмөрийн гавъяаны Улаан туг”-ийн одонгоор, шүүгч



**П.Золзаяа**, Төсвийн асуудал хариуцсан референт-Ахлах нягтлан бодогч  
**А.Эрдэнэцэцэг**, Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан шинжээч **Б.Хишигсүрэн**  
нарыг “Алтангадас” одонгоор, Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга  
**Н.Булгамааг** “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар тус тус шагнагдлаа.

Мөн шүүгч **О.Зандраа** нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2016 оны **59**  
дүгээр зарлигаар Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилогджээ.



### Шүүн таслах нэр их ажлын зэрэгцээ, шүүгч ажилтнууд маань:

- “Монгол Улсын Дээд шүүх-2015”;
- “Иргэний хуулийн тайлбар /Гэрээний бус үүрэг IV/”
- “Оюуны өмчийн эрх зүй”
- “Монголын төр эрх зүй” сэтгүүл зэрэг ном, сэтгүүл дангаар болон хамтран бүтээж, нийтийн хүртээл болголоо.


Мөн Монгол Улсад орчин цагийн шүүх байгуулагдсаны 105 жил, Улсын Дээд шүүхийн 90 жилийн ойд зориулсан “**Монголын шүүх I, II, III**” ботиудыг хэвлүүлээд байна.






## УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

### Улсын Дээд шүүхийн нийт хүлээж авсан 2726 хэргээс




### Шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн 2250 хэргээс







**Улсын Дээд шүүхийн эрүү, иргэн болон захиргааны хэргийн танхимуудын 2016 онд хүлээж авсан хэргийг өмнөх онтой харьцуулбал:**



**2016 онд шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэргийг өмнөх онтой харьцуулбал:**



**Улсын Дээд шүүхийн нэг шүүгчид ногдох хэргийн ажлын ачааллыг өмнөх онтой харьцуулбал:**





ЭРҮҮГИЙН  
ХЭРГИЙН  
ТАНХИМ






## НЭГ. ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

### 1.1. Эрүүгийн хэргийн танхим.

Эрүүгийн хэргийн танхим 2015 оны үлдэгдэл 8 хэрэг дээр 2016 онд хяналтын шатны журмаар эрүүгийн 444, цагаатгалын 2, нийт 454 хэрэг хүлээн авч, эрүүгийн 335, цагаатгалын 2 буюу нийт 337 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, 88 хэргийг албан бичгээр буцааж, 23 хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, 6 хэргийн үлдэгдэлтэй байна.

### Нийт хүлээн авсан эрүүгийн 454 хэргээс



Эрүүгийн хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт 69 өдөр хуралдаж, өдөрт дунджаар 4.8 хэрэг хэлэлцжээ.

Эрүүгийн хэргийн танхимд хяналтын шатны журмаар ирүүлсэн хэргээс нэг шүүгчид 84.6 хэрэг ногдож байна.

Хяналтын журмаар шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн 337 хэргийн 49.5 хувь буюу 167 хэргийн тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, 24 хувь буюу 81 хэргийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулж, 26.4 хувь буюу 89 хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгожээ.




Өөрчлөлт оруулсан **81** хэргийн **19.7** хувь буюу **16** хэргийг Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн, **6.1** хувь буюу **5** хэргийг шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, **4.9** хувь буюу **4** хэргийг хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, **14.8** хувь буюу **12** хэргийг Эрүүгийн хуулийн 55<sup>1</sup>, 62<sup>1</sup> дүгээр зүйлээр, **7.4** хувь буюу **6** хэргийг хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн, **46.9** хувь буюу **38** хэргийг бусад гэсэн үндэслэлүүдээр өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон **89** хэргийн **57.3** хувь буюу **51** хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр **прокурорт**, **22.4** хувь буюу **20** хэргийг **шүүхээр дахин хэлэлцүүлэхээр** буцааж, **7.8** хувь буюу **7** хэргийг (үүнээс 2.2 хувь буюу 2 нь цагаатгалын хэрэг) **хэрэгсэхгүй** болгож, **12.3** хувь буюу **11** хэргийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгожээ.

Хяналтын журмаар шүүгч Ч.Хосбаяр **81**, Д.Ганзориг **80**, Б.Цогт **80**, Д.Эрдэнэбалсүрэн **80**, Б.Батцэрэн **79**, Б.Бат-Эрдэнэ **31**, Ерөнхий шүүгчийн ажлын алба **23** эрүүгийн хэрэг тус тус хүлээн авчээ.

### Шүүгч тус бүрийн болон Ерөнхий шүүгчийн ажлын албаны хүлээн авсан хэрэг




Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Т.Уранцэцэг **226**, шүүгч Б.Цогт **289**, Ч.Хосбаяр **272**, Д.Ганзориг **268**, Д.Эрдэнэбалсүрэн **268**, Б.Батцэрэн **256**, Б.Бат-Эрдэнэ **106** тус тус **оролцсоноос**;

Танхимын тэргүүн Т.Уранцэцэг **226**, шүүгч Б.Батцэрэн **65**, Б.Бат-Эрдэнэ **23**, Д.Ганзориг **11**, Д.Эрдэнэбалсүрэн **9**, Ч.Хосбаяр **3** хэргийн шүүх хуралдааныг даргалж;

Шүүгч Б.Цогт **68**, Д.Ганзориг **64**, Ч.Хосбаяр **62**, Б.Батцэрэн **60**, Д.Эрдэнэбалсүрэн **59**, Б.Бат-Эрдэнэ **24** хэргийг илтгэсэн байна.



## Эрүүгийн хэргийн танхимын шүүгчдийн 2016 оны бүтэн жилийн ажлын ачаалал



2016 онд цагаатгал хариуцсан шинжээчээс Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн төрөл садан болон Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссуудаар дамжуулан **37** өргөдөл, хүсэлтийг хүлээн авч нийтдээ **31** цагаатгалын үнэмлэх олгосноос **16** үнэмлэх шинээр, **15** үнэмлэх нөхөн олгож, цагаатгалын үнэмлэх олгох боломжгүй талаар **6** өргөдөл, хүсэлтэд албан бичгээр хариу өгсөн байна.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн цагаатгалын **3** хүнд холбогдох **2** хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож, тэднийг цагаатгаж шийдвэрлэжээ.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **94.3** хувь буюу **318** хэргийг ялтан, хохирогч, тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн **гомдлоор**, **0.5** хувь буюу **2** хэргийг иргэний хариуцагчийн гомдлоор, **1.4** хувь буюу **5** хэргийг улсын яллагчийн **эсэргүүцлээр**, **3.5** хувь буюу **12** хэргийг прокурорын **дүгнэлтээр** хэлэлцэгджээ.

Тайлангийн хугацаанд шүүгч Д.Эрдэнэбалсүрэн **21**, Ч.Хосбаяр **18**, Б.Батцэрэн **16**, Д.Ганзориг **16**, Б.Цогт **10**, Б.Бат-Эрдэнэ **7**, нийт **88** хэргийг хянаж албан бичгээр буцаасан байна.

Эрүүгийн хэргийн танхим 2016 онд нийт **108** албан бичиг, **29** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн Т.Уранцэцэг **51** албан бичиг, **11** өргөдөл гомдол, шүүгч Б.Цогт **16** албан бичиг, **1** өргөдөл гомдол, шүүгч Ч.Хосбаяр **14** албан бичиг, **3** өргөдөл гомдол, шүүгч Б.Батцэрэн **9** албан бичиг, **3** өргөдөл гомдол, шүүгч Д.Ганзориг **9** албан бичиг, **1** өргөдөл гомдол, шүүгч



Д.Эрдэнэбалсүрэн **6** албан бичиг, **7** өргөдөл гомдол, шүүгч Б.Бат-Эрдэнэ **1** албан бичиг, **1** өргөдөл гомдол тус тус хянан шийдвэрлэж, одоо Танхимын тэргүүн Т.Уранцэцэг **1** албан бичиг, **1** өргөдөл гомдол, шүүгч Б.Цогт **1** албан бичиг, **1** өргөдөл гомдлын үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний захирамж **466** гаргаснаас шүүхийн харьяалал тогтоох тухай **33**, хэрэг хянан шийдвэрлэх хугацаа сунгах тухай **47**, шүүх бүрэлдэхүүн томилох тухай **386** захирамж гарчээ. Мөн тайлангийн хугацаанд шүүхийн тогтоол **55**, мэдэгдэх хуудас **86** гарсан байна.



ИРГЭНИЙ  
ХЭРГИЙН  
ТАНХИМ



## 1.2. Иргэний хэргийн танхим

Иргэний хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл **59** хэрэг дээр хяналтын шатны журмаар **1546**, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан **53**, шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар **53**, нийт **1711** хэрэг хүлээн авч, **1469** хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, **72** хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, **55** хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар хэлэлцэж, **46** хэргийг хяналтын журмаар хэлэлцэхээс татгалзаж, **13** хэргийн харьяаллыг тогтоож **56** хэргийн үлдэгдэлтэй байна.

### Нийт хүлээн авсан 1711 хэргээс



**Иргэний хэргийн танхимын** хяналтын шатны шүүх хуралдаан нийт **95** өдөр хуралдаж, **өдөрт** дунджаар **15,5** хэрэг хэлэлцжээ.

Иргэний хэргийн танхимд хяналтын шатны журмаар ирүүлсэн **1639** хэргээс нэг шүүгчид **234.1** хэрэг тус тус ногдож байна.

Хяналтын журмаар хэлэлцэгдсэн иргэний **1469** хэргийн **54** хувь буюу **793** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **12** хувь буюу **177** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцааж, **20.6** хувь буюу **303** хэргийн шийдвэр, магадлалд нэмэлт, өөрчлөлт оруулж, **10.7** хувь буюу **158** хэргийн магадлалыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилж, **2.7** хувь буюу **38**




хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон байна.

Өөрчлөлт оруулсан **303** шийдвэр, магадлалын **85.1** хувь буюу **258** нь хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хууль хэрэглэсэн, хууль буруу тайлбарлаж хэрэглэсэн, **14.9** хувь буюу **45** нь шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулжээ.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож хэргийн дахин хэлэлцүүлэхээр буцаасан **177** хэргийн **38.4** хувь буюу **68** хэргийг шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй гэж, **61.5** хувь буюу **109** хэргийг шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаажээ. Үүнээс **2** хэргийг давж заалдах шатны шүүхээр дахин хянан хэлэлцүүлэхээр буцаасан байна. Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан **38** хэргийн **47.4** хувь буюу **18** нь шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, **52.6** хувь буюу **20** нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн байна.

**Хяналтын журмаар** Танхимын тэргүүн Х.Сонинбаяр **43**, П.Золзаяа **239**, Ц.Амарсайхан **238**, шүүгч Г.Цагаанцоож **237**, Б.Ундрах **236**, Г.Алтанчимэг **235**, Х.Эрдэнэсүвд **235**, Д.Цолмон **176** хэрэг хүлээн авчээ.

## Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг






**Хяналтын шатны** Иргэний хэргийн шүүх хуралдаанд шүүгч П.Золзаяа **731**, Г.Алтанчимэг **726**, Х.Эрдэнэсүвд **706**, Г.Цагаанцоож **699**, Ц.Амарсайхан **691**, Б.Ундрах **535**, Д.Цолмон **484** удаа **оролцсоноос**;

Танхимын тэргүүн Х.Сонинбаяр **1352**, шүүгч Г.Цагаанцоож **77**, Ц.Амарсайхан **48**, П.Золзаяа **21**, Б.Ундрах **21**, Х.Эрдэнэсүвд **4**, Г.Алтанчимэг **1** хуралдааныг тус тус **даргалж**;

Танхимын тэргүүн Х.Сонинбаяр **30**, шүүгч П.Золзаяа **231**, Г.Цагаанцоож **229**, Ц.Амарсайхан **223**, Б.Ундрах **222**, Г.Алтанчимэг **220**, Х.Эрдэнэсүвд **205**, Д.Цолмон **164** хэргийг **илтгэсэн** байна.

### Иргэний хэргийн танхимын шүүгчдийн 2016 оны бүтэн жилийн ажлын ачаалал



Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **578** нэхэмжлэгчийн, **872** хариуцагчийн, **19** гуравдагч этгээдийн гомдлоор хянан хэлэлцэгджээ.

Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **1469** хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

Иргэний хуулиар **998**, Хөдөлмөрийн тухай хуулиар **296**, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар **68**, Гэр бүлийн тухай хуулиар **49**, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар **4**, бусад хуулиар **54** хэргийг хянан шийдвэрлэжээ.

Мөн энэ хугацаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээс хяналтын журмаар гаргасан гомдолд нийт **829.628.400** /найман зуун хорин есөн сая зургаан





зуун хорин найман мянга дөрвөн зуу/ төгрөгийг улсын тэмдэгтийн хураамжид төлсний **357.389.600** /гурван зуун тавин долоон сая гуван зуун наян есөн мянга зургаан зуу/ төгрөгийг буцаан олгожээ.

Тус танхим 2016 онд нийт **125** албан бичиг, **60** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн Х.Сонинбаяр **71** албан бичиг, **32** өргөдөл гомдол, шүүгч Г.Цагаанцоож **11** албан бичиг, **4** өргөдөл гомдол, шүүгч П.Золзаяа **12** албан бичиг, **6** өргөдөл гомдол, Х.Эрдэнэсүвд **11** албан бичиг, **3** өргөдөл гомдол, Д.Цолмон **6** албан бичиг, **7** өргөдөл гомдол, Б.Ундрах **4** албан бичиг, **4** өргөдөл гомдол, Г.Алтанчимэг **4** албан бичиг, **2** өргөдөл гомдол, Ц.Амарсайхан **2** албан бичиг тус тус хянан шийдвэрлэж, одоо **4** албан бичиг, **2** өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй байна.

**Иргэний хэргийн танхим 2016 оны бүтэн жилийн байдлаар улс төрийн намын бүртгэлийн талаар дараах ажлыг хийжээ. Үүнд:**

- Монгол Ардын намын үндсэн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж;
- Монголын оюун санааны хувьсгалт намыг 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 02 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж;
- Монголын Залуучуудын хөдөлгөөний намыг 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж;
- Хөгжлийн хөтөлбөр намын дүрэм болон, намын лого, намын даргын өөрчлөлтийг 2016 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж;
- Монголын Удирдлага Хөгжлийн Нэгдсэн намыг 2016 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 05 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж,
- Хөдөлмөрийн үндэсний намын даргын өөрчлөлтийг 2016 оны 04 дүгээр дугаар сарын 15-ны өдрийн 10 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж;
- Хамуг Монголын Хөдөлмөрийн намын даргын өөрчлөлтийг 2016 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 08 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж;
- Монголын Консерватив намын дүрмийн өөрчлөлтийг 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж;



- Хөдөлмөрийн Үндэсний намын даргын өөрчлөлтийг 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 10 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж;
- Тусгаар тогтнол, Эв нэгдлийн намын дарга болон намын дүрмийн өөрчлөлтийг 2016 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж;
- Иргэний Зориг, Ногоон намын даргын өөрчлөлтийг 2016 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 12 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж;
- Эх Орон намын дүрмийн өөрчлөлтийг 2016 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 15 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж;
- Монголын Либерал намын удирдлагын бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийг 2016 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 16 дугаар тогтоолоор бүртгэж;
- Иргэний Зориг, Ногоон намын даргын өөрчлөлтийг 2016 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 18 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж;
- Иргэний Хөдөлгөөнийн намын туг, далбааны өөрчлөлтийг 2016 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж;
- Тусгаар тогтнол, эв нэгдлийн намын даргын өөрчлөлтийг 2016 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 20 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж;
- Үнэн ба зөв намыг 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж;
- Ардчилсан намын дүрэм, журмын өөрчлөлтийг 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 22 дугаар тогтоолоор бүртгэсэн байна.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж **2141** гаргаснаас Танхимын тэргүүний “Шүүх бүрэлдэхүүн томилох тухай” **1665**, “Улсын тэмдэгтийн хураамж буцааж олгох тухай” **430**, “Гомдол хэлэлцүүлэхээс татгалзах тухай” **25**, “Гомдол гаргаагүйд тооцох тухай” **21** шүүгчийн захирамж тус тус гарчээ.



ЗАХИРГААНЫ  
ХЭРГИЙН  
ТАНХИМ



### 1.3. Захиргааны хэргийн танхим.

Захиргааны хэргийн танхимын өмнөх оны үлдэгдэл **31** хэрэг /хяналтын журмаар гомдол гаргасан **19**, Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай **4**, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан **8** хэрэг/ дээр 2016 онд хяналтын шатны журмаар **465** захиргааны хэрэг, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан **26**, шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар **18**, Шүүхийн ёс зүйн хорооны гомдолтой **14**, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэртэй **7** нийт **561** хэрэг хүлээн авч, **444** хэргийг хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар, **48** хэргийг хуралдаанд оролцуулахгүйгээр, гомдлыг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжид гомдол гаргасан **4** хэргийг, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай **21** хүсэлтийг шийдвэрлэж, **31** хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанаас хариу өгч, одоо **13** хэргийн /хяналтын журмаар гомдол гаргасан **9**, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах **1**, ерөнхий шүүгчийн ажлын алба **3**/ үлдэгдэлтэй байна.

#### Нийт хүлээн авсан 561 хэргээс



**Захиргааны хэргийн танхимын** хяналтын шатны шүүх хуралдаан нийт **49** өдөр хуралдаж, **өдөрт** дунджаар **9.4** хэрэг хэлэлцжээ.

Захиргааны хэргийн танхимд хяналтын шатны журмаар ирүүлсэн **481** хэргээс нэг шүүгчид **96.2** хэрэг тус тус ногдож байна.



Хяналтын шатны журмаар хэлэлцэгдсэн захиргааны **444** хэргийн **66.2** хувь буюу **294** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **14.4** хувь буюу **64** хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, **19.3** хувь буюу **86** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгожээ.


Шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон **86** хэргийн **21** хувь буюу **18** хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж, **26.7** хувь буюу **23** хэргийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, **2.3** хувь буюу **2** хэргийг хэрэгсэхгүй болгож, **3.4** хувь буюу **3** хэргийн нэхэмжлэлийг хангасан, **46.5** хувь буюу **40** хэргийн магадлал хүчингүй, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөлт оруулсан байна.

Шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулсан **64** хэргийн **42.1** хувь буюу **27** нь хууль буруу хэрэглэсэн, **26.5** хувь буюу **17** нь шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, **31.2** хувь буюу **20** шийдвэр, магадлалд бусад өөрчлөлт оруулсан.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай **21** хэргийн **19** хэргийн хүсэлтийг хангаагүй, **2** хэргийн хүсэлтийг хангаж, одоо **1** хэргийн үлдэгдэлтэй байна.

Хяналтын журмаар шүүгч Л.Атарцэцэг **97**, Х.Батсүрэн **96**, Д.Мөнхтуяа **96**, П.Соёл-Эрдэнэ **96**, Ч.Тунгалаг **96**, О.Зандраа **30**, Ц.Сумъяа **16** захиргааны хэрэг тус тус хүлээн авчээ.

### Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг




Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд шүүгч Ч.Тунгалаг **264**, П.Соёл-Эрдэнэ **248**, Х.Батсүрэн **247**, Л.Атарцэцэг **236**, Д.Мөнхтуяа **217**, О.Зандраа **74**, Ц.Сумъяа **46** удаа тус тус **оролцож**,



Танхимын тэргүүн М.Батсуурь **382**, шүүгч Х.Батсүрэн **45**, Ц.Сумъяа **9**, Л.Атарцэцэг **5**, Ч.Тунгалаг **3** хэргийн шүүх хуралдааныг тус тус **даргалж**;

Шүүгч Ч.Тунгалаг **86**, П.Соёл-Эрдэнэ **83**, Л.Атарцэцэг **80**, Д.Мөнхтуяа **79**, Х.Батсүрэн **77**, О.Зандраа **25**, Ц.Сумъяа **14** хэрэг тус тус **илтгэсэн** байна.

### Захиргааны хэргийн танхимын шүүгчдийн 2016 оны ажлын ачаалал



Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн нийт хэргийн **155** нь хэргийн оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн, **119** нь нэхэмжлэгчийн, **84** нь хариуцагчийн, **68** нь өмгөөлөгчийн, **18** нь гуравдагч этгээдийн гомдлоор хянан хэлэлцэгджээ.

Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **444** хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

- Газрын маргаан **110**;
- Төрийн албаны маргаан **88**;
- Ашигт малтмалын маргаан **49**;
- Татварын маргаан **46**;
- Сонгуулийн маргаан **16**;
- Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлтэй холбоотой маргаан **15**;
- Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалтай **14**;
- Нийгмийн даатгал **9**;
- Төрийн хяналт шалгалт **8**;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай маргаан **5**;
- Бусад маргаан **84** байна.

Мөн хугацаанд нэхэмжлэгч, гуравдагч этгээдээс хяналтын журмаар гаргасан гомдолд нийт **21,495,600** /хорин нэгэн сая дөрвөн зуун ерэн таван



мянга зургаан зуу/ төгрөгийг улсын тэмдэгтийн хураамжид төлсний **3,931,200** /гурван сая есөн зуун нэг мянга хоёр зуу/ төгрөгийг буцаан олгожээ.

Тус танхим **2016 онд** нийт **35** албан бичиг, **30** өргөдөл, гомдол хүлээн авснаас: Танхимын тэргүүн М.Батсуурь **24** албан бичиг, **15** өргөдөл гомдол, шүүгч Х.Батсүрэн **3** албан бичиг, **2** өргөдөл гомдол; О.Зандраа **3** албан бичиг, **2** өргөдөл гомдол; Ч.Тунгалаг **2** албан бичиг, **4** өргөдөл гомдол; Д.Мөнхтуяа **2** албан бичиг, **3** өргөдөл гомдол; Л.Атарцэцэг **3** өргөдөл гомдол; Ц.Сумъяа **1** албан бичгийг тус тус хянан шийдвэрлэж, **1** өргөдлийн үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд Танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол **826** гаргаснаас “бүрэлдэхүүн томилох тухай” **328**, “шүүх хуралдааныг хойшлуулах тухай” **137**, “улсын тэмдэгтийн хураамж буцаах тухай” захирамж **57**, “шинээр илэрсэн нөхцөл байдлын хүсэлтийг шийдвэрлэх тухай” шүүхийн тогтоол **21**, “гомдол хэлэлцэхээс татгалзах тухай” **31**, “гомдол гаргаагүйд тооцох тухай” **26**, бусад захирамж, тогтоол **226** гарсан байна.



## ХОЁР. БУСАД АСУУДЛААР

### Энэ хугацаанд Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид

- “Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга”;
- “Зөрчлийн тухай”;
- “Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай”;
- “Зөрчил шалган шийдвэрлэх тухай”;
- “Эрүүгийн болон Захиргааны хариуцлагын тухай” хуулийн төсөлд;

### Иргэний хэргийн танхимын шүүгчид

- “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”;
- “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”;
- “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай” хуулиуд;
- “Зөрчлийн тухай” хууль;
- “Арбитрын тухай” хууль;
- “Шүүмжлэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн төсөлд;

### Улсын Дээд шүүхийн шүүгч нар

- “Гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой эрх зүйн маргаанаас урьдчилан сэргийлэх, маргааныг хэлэлцээний замаар шийдвэрлэх, маргаан үүсэхэд баримтлах журам”;
- “Иргэний хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал” журам;
- “Архивын ажиллах журам”-ын төсөлд тус тус санал өгч, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үүргээ хэрэгжүүлжээ.

Харин Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн **Т.Уранцэцэг** Шүүхийн мэргэшлийн хорооны даргаар;

Шүүгч **Б.Батцэрэн, Б.Бат-Эрдэнэ, Д.Мөнхтуяа** нар Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүнээр;

Шүүгч **Б.Батцэрэн** “Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системийг хэрэгжүүлэх” ажлын хэсгийн ахлагчаар, шүүгч **Ч.Хосбаяр** гишүүнээр, Шүүгчийн туслах-шинжээч **Г.Ууганбаатар** ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар;

Шүүгч **Б.Батцэрэн, Ч.Хосбаяр** нар “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” болон “Хууль сахиулах ажиллагааны тухай” хуулийн төслүүдийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр;





Шүүгч **Б.Батцэрэн** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо болон нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүнээр;

Шүүгч **Ч.Хосбаяр** “Шилдэг тогтоол, магадлал шалгаруулах” комиссын ажлын хэсгийн гишүүнээр;

Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь** “Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системийг зүгшрүүлэх” ажлын хэсгийн ахлагчаар;

Захиргааны ерөнхий хуулийн тайлбар бичих ажлын хэсгийн гишүүнээр;

Иргэний хэргийн танхимын тэргүүн **Х.Сонинбаяр**, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгийн ахлагчаар, шүүгч **Б.Ундрах, Г.Цагаанцоож** нар гишүүнээр,

Шүүгч **Г.Алтанчимэг** “Арбитрын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын ажлын хэсгийн гишүүнээр;

Шүүгч **Ц.Амарсайхан** “Гэр бүлийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль”-ийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр;

“Шүүхийн сонгомол шийдвэр шалгаруулах” ажлын хэсгийн гишүүнээр;

Шүүгч **П.Золзаяа** “Арбитрын тухай хуулийн болон Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль”-иудын шинэчилсэн найруулгын ажлын хэсгийн гишүүнээр;

Шүүгч **Д.Мөнхтуяа** “Шүүх эрх мэдэл” сэтгүүлийн редакцийн зөвлөлийн гишүүнээр;

Монголын шүүгчдийн холбооны Улсын Дээд шүүхийн шүүгчдийн холбооны салбар зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүнээр;

Монголын шүүгч эмэгтэйчүүдийн холбооны гишүүнээр;

IDLO шүүгч сургах төслийн сургагч багшаар;

Шүүгч **Ч.Тунгалаг** “Монголын төр, эрх зүй” сэтгүүлийн редакцийн зөвлөлийн гишүүнээр;

Шүүгч **Б.Бат-Эрдэнэ** Хууль сахиулах Их сургуулийн докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүнээр, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Шихихутуг хууль зүйн дээд сургууль, Билэг дээд сургууль, Тагнуулын үндэсний академийн магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүнээр;

Шүүгч **Б.Батцэрэн** Монголын хуульчдын холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, Шүүгчдийн хорооны Удирдах зөвлөлийн гишүүнээр;

Шүүгч **Д.Эрдэнэбалсүрэн** Монголын Хуульчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүнээр тус тус ажилласан байна.



Мөн Иргэний хэргийн танхим өнгөрсөн хугацаанд “Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар 2015 онд хянагдсан хэргийн судалгаа, цаашид анхаарах зарим асуудлын талаар” тойм;

“Нэхэмжлэлийн үндэслэл, шаардлагыг тодорхойлоход анхаарах зарим асуудал” сэдвээр зөвлөмж;

“Эрх зүйн маргаантай харилцааг тогтоох, хуулийн холбогдох зохицуулалтыг зөв тайлбарлан хэрэглэх шүүгчийн ажиллагаа” сэдвээр зөвлөмж;

“Гэрээний зарим эрх зүйн маргааны хууль хэрэглээ болон гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахад анхаарах асуудлууд” сэдвээр зөвлөмж;

“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан зарим ажиллагааны талаар” сэдвээр зөвлөмж тус тус боловсруулж, холбогдох шүүх, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлжээ.

Иргэний хэргийн танхимын тэргүүн **Х.Сонинбаяр** шүүгч багш нарын сургалтын бэлтгэлийг хангах, иргэний хэргийн шүүхийн шүүгч нарын сургалтанд зориулсан “Үүргийн гүйцэтгэлийг хангах арга ба Иргэний хуулийн хэрэглээ, шүүхийн шийдвэр боловсруулах арга зүй” гарын авлагыг боловсруулах, хянан гаргах ажлыг хийжээ.

Шүүгч **П.Золзаяа** “Үүргийн гүйцэтгэлийг хангах ба Иргэний хуулийн хэрэглээ, шүүхийн шийдвэр боловсруулах арга зүй” сургалтын гарын авлагын 1 дүгээр хэсэг “Барьцаа түүний нийтлэг зохицуулалт” сэдвийг бичжээ.



## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2016 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

### 1. Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах чиглэлээр:

Шүүхийн тамгын газар нь Шүүхийн тухай багц хууль, Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль, тэдгээрт нийцүүлэн гарсан дүрэм, журам, заавар, Улсын Дээд шүүхийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг зохих ёсоор гүйцэтгэх, Шүүхийн захиргааны тухай хуулийн **6-12** дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх талаар анхааран ажиллалаа.

Захиргаа удирдлагын хэлтсээс Авлигын эсрэг хууль, “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-д заасны дагуу шүүгч, захиргааны албан хаагчдаас “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг 2015 оны байдлаар шинэчлэгдсэн маягтыг дахин гаргуулан авч, **25** шүүгчийн материалыг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн Сахилгын хороонд, **1** хүний материалыг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн ажлын албанд, **50** захиргааны албан хаагчийн материалыг Тамгын газарт зохих журмын дагуу хадгалж, цахим хэлбэрээр шинэчлэн гаргуулсан байна.

Мөн захиргааны албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн **4** хүний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг “**Авлигатай тэмцэх газар**”-т хянуулахаар хүргүүлэн холбогдох зөвшөөрлийг авч, шийдвэрлэжээ.

Түүнчлэн “**Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан**”-г шинэчилсэн програмын дагуу гаргаж, Төрийн албаны зөвлөл, Шүүхийн ерөнхий зөвлөлд тогтсон хугацаанд нь хүргүүлсэн байна.

Тайлангийн хугацаанд Тамгын газрын дарга хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн нийт **149** тушаал гаргасан байна.

“Билгийн тооллын хаврын тэргүүн сар-Цагаан сарын баяр”, “Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр”, “Хүүхдийн баяр”, “Үндэсний их баяр наадмын өдөр”, “Их Эзэн Чингис хааны өдөр”, “Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр”, “Шинэ жилийн баярын өдөр” болон бусад тэмдэглэлт баяр, бүх нийтийн амралтын өдрүүдэд тухай бүр арга хэмжээг зохион байгуулж, Улсын Дээд шүүх дээр сахилга, хариуцлага, дэг журам, сонор сэрэмжийг өндөржүүлэх




зорилгоор Тамгын газрын даргын 9 удаагийн тушаалаар 16 ажилтныг хариуцлагатай эргүүлээр томилон ажиллуулжээ.

Мөн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д “Хуульч, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсны дараа шүүхэд төлөөлөх эрх нээлгэхээр Улсын Дээд шүүхэд бүртгүүлж ... өмгөөлөгчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдэнэ.” гэж заасны дагуу Тамгын газрын даргын тушаалаар 2013 оноос одоог хүртэл **2403**, энэ онд **219** хуульчдад өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхийг тус тус нээж, гэрчилгээ, үнэмлэх олгоод байна.

Тайлангийн хугацаанд **311** өргөдөл гомдол, **932** албан бичиг, **2703** хавтаст хэрэг хүлээн авч, зохих журмын дагуу бүртгэн, бүртгэл хяналтын карт нээж, уг албан бичгүүдийг Ерөнхий шүүгч, Тамгын газрын даргад танилцуулсны дагуу шүүгч, ажилтнуудад хувиарлан өгч шийдвэрлүүлснээс гадна **3767** албан бичигт дугаар өгч холбогдох шүүх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад явуулжээ.

Өргөдөл гомдол, албан бичгийг өмнөх онтой харьцуулж үзвэл:



Улсын Дээд шүүх цахим шүүх болох зорилтын хүрээнд өөрийн цахим хуудсанд “Хяналтын шатны шүүх хуралдааны статистик мэдээ” буланг 2016 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн байршуулаад байна.

Улсын Дээд шүүхээс анхан болон давж заалдах шатны Ерөнхий шүүгч нарт зориулсан “Шүүн таслах ажиллагаа, шүүхийн шийдвэрийн талаарх практик” сэдэвт уулзалт-ярилцлага сургалтыг 2016 оны 2 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд нийт **120** гаруй Ерөнхий шүүгч, шүүгчид оролцжээ.

Уулзалт-ярилцлагыг Улсын Дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын тэргүүн, шүүгчид удирдан явуулсан бөгөөд эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон шинээр батлагдсан зарим хуулиудын үзэл баримтлал, тэдгээрийг хэрхэн хэрэглэх, тодорхой төрлийн хэрэг маргааныг шийдвэрлэхэд анхаарах асуудлын талаар анхан болон давж заалдах



шатны шүүхийн Ерөнхий шүүгч нарт мэдээлэл хийж, харилцан санал бодлоо солилцсон байна.

Мөн Улсын Дээд шүүхээс Монгол Улсад орчин цагийн шүүх байгуулагдсаны 105, Монгол Улсын Дээд шүүх байгуулагдсаны 90 жилийн ойн хүрээнд “**ШҮҮХИЙН СПОРТЫН ИХ НААДАМ-2016**” тэмцээнийг 2016 оны 11 дүгээр сарын 09-11-ний өдрүүдэд сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, шатар гэсэн спортын 4 төрлөөр “Буянт-Ухаа” спортын ордонд амжилттай зохион байгууллаа.

Тус “**Шүүхийн спортын их наадам-2016**” тэмцээнд багийн дүнгээр **Б.Цогт** ахлагчтай, Улсын Дээд шүүхийн баг **36** оноогоор тэргүүлсэн амжилт үзүүлжээ.

Түүнчлэн 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр ойн баярын хурал, хүндэтгэлийн арга хэмжээг “Соёлын төв өргөө”, “Corporate Convention Centre-Event hall” танхимд зохион байгуулахаар бэлтгэл ажил хангагдаад байна. Энэхүү үйл ажиллагаанд анхан болон давж заалдах шатны шүүхүүдийн Ерөнхий шүүгч нар, шүүхүүдийн төлөөлөл болон үе үеийн ахмадууд нийт 1200 гаруй зочид төлөөлөгч оролцох юм.

### Шүүхийн хүний нөөцийн чиглэлээр:

Мөн өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн шүүгч **Ц.Сумъяаг** Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2016 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн **76** дугаар зарлиг, шүүгч **Б.Бат-Эрдэнийг** Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2016 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн **142** дугаар зарлигаар Улсын Дээд шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлжээ.

Тайлангийн хугацаанд **А.Эрдэнэтийг** Тамгын газрын туслах-шинжээчийн **Ө.Учрал**, **Б.Володя** нарыг Шүүгчийн туслах-шинжээчийн, **З.Оюунгэрэлийг** Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга-мэргэжилтний албан тушаалд, **Д.Бямбадоржийг** Сантехникийн слесарын ажилд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн тус тус томилж, өөрийн хүсэлтээр төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан Захиргааны хэргийн шүүн таслах ажиллагаа хариуцсан зөвлөх **Н.Дагва**, Шүүгчийн туслах-шинжээч **Д.Батхуяг**, **Б.Өлзийхишиг**, жолооч **Д.Төмөрхуяг** нарыг чөлөөлсөн байна.

Түүнчлэн Тамгын газрын даргын тушаалаар Захиргааны хэргийн хууль тогтоомж, практик ажил хариуцсан-шинжээч **Ш.Даваадуламыг** Эрх зүйн онол, арга зүйн асуудал хариуцсан референтийн, Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга-мэргэжилтэн **Б.Наранжаргалыг** Шүүгчийн туслах-шинжээчийн албан тушаалд дэвшүүлэн ажиллууллаа.

### Тайлангийн хугацаанд:



Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн туслах-референт **Б.Бямбаабаатар**, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний туслах-Ахлах шинжээч **Ц.Батзаяа**, Шүүгчийн туслах-шинжээч **Д.Батхуяг**, **Л.Хэрлэнчимэг** нарын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг;

Шүүгчийн туслах-шинжээч **Т.Болортуяа**, **Т.Жавхлантөгс**, **С.Золбоо**, **Н.Нямдаваа**, **Б.Өлзийхишиг**, Иргэний хэргийн хууль тогтоомж, практик ажил хариуцсан шинжээч **Н.Мөнгөнцэцэг** нарын зэрэг дэвийг тус тус шинээр олгожээ.

Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын дагуу давхардсан тоогоор **63** хүний үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх, **21** хүний хөдөлмөрийн гэрээг байгуулах ажлыг хагас, бүтэн жилээр зохион байгуулсан байна.

Мөн Захиргааны хэргийн хууль тогтоомж, практик ажил хариуцсан шинжээч **Б.Энхбат**, Гэмт хэргийн тухай хууль тогтоомж, практик ажил хариуцсан-шинжээч **А.Баярцэцэг**, Шүүгчийн туслах-шинжээч **И.Бямбасүрэн**, **Ө.Учрал**, Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга **Ш.Мөнхжаргал** нарын Төрийн албан хаагчийн тангараг өргөх ёслолын ажиллагааг 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдөр зохион байгууллаа.

## 2. Шүүхийн практик судлах чиглэлээр:

Тус хэлтсээс тойм, зөвлөмж гаргах, эрх зүйн онол, хууль зүйн харьцуулалт, шүүхийн практикийн тоон болон чанарын **28** судалгааны ажил хийж, тайлан, танилцуулга бичжээ.

Эрүү, иргэний болон захиргааны хэргийн хяналтын шатны шүүхээр хянагдсан хэргүүдийн өөрчлөгдсөн, хүчингүй болсон шалтгаан нөхцлийг 2015, 2016 оны хагас жилийн байдлаар судалж, **6** тойм бичиж, нийтийн хүртээл болгосон байна.

Тус хэлтсийн ажилтнууд эрүү, иргэн, захиргааны шүүн таслах ажлын тоон судалгааг хэргийн төрөл болон маргааны төрлөөр судалж олон тойм, танилцуулга бичсэн болно.

Тухайлбал, Эрүү, иргэний шүүн таслах ажиллагааны судалгааг /анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүх/ 2002-2016 он буюу 14 жилээр, захиргааны шүүн таслах ажиллагааны судалгааг 2004-2016 он буюу 12 жилээр хийж гүйцэтгэн **“Монголын шүүх-II”** боть номонд оруулж хэвлүүллээ.

Түүнчлэн нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлийг зөв тогтоох шүүгчийн ажиллагаа, гэрээний эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг



шийдвэрлэж буй шүүхийн практик, эрх зүйн маргаантай харилцааг зөв тогтоохын тулд анхан болон давж заалдах шатны шүүхүүдийн шийдвэр, магадлал хүчингүй болсон шалтгааны талаарх тойм;

Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуулийн хэрэгжилтийн талаарх судалгаа болон танилцуулга;

Эрүүгийн хуулийн 40, 49, 89, 90, 166, 175, 148, 188, 192, 194, 268, 269, 270 дугаар зүйлүүдээр шийдвэрлэсэн хэргийн судалгааг 3-10 жилээр гаргаж, тус бүрт нь тойм, танилцуулга;

2015 онд Улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн танхимын хянан тогтоосон хэргийн шийдвэр /өмнөх шатны шүүхүүдийн шийдвэрийг хянасан байдал/, маргааны төрөл засаг захиргааны харьяаллаар судалгаа;

“Хуулийн хүчин төгөлдөр болсон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянах эрх зүйн зохицуулалт”-ын судалгаа;

“Сонгуулийн маргааныг Улсын Дээд шүүхэд хянан шийдвэрлэсэн тогтоолын хэлбэр, түүний эрх зүйн үндэс” судалгаа;

2005-2015 онд шүүхээр онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон этгээдийн талаарх судалгаа;

2014, 2015 онд шүүхээр ял шийтгүүлсэн эмэгтэй болон насанд хүрээгүй ял шийтгүүлэгчдийн талаарх судалгаа, танилцуулгыг тус тус гаргасан байна.

Мөн Үндсэн хуулийн цэцийн захиалгаар анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүн таслах ажлын судалгааг сүүлийн 10 жилээр гаргаж хүргүүлсэн байна.

“НҮБ-ын хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө” батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд санал өгчээ.

Түүнчлэн Монгол банкны хүсэлтээр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол Улсын тогтолцоо, ФАТФ-ын зөвлөмжийн хэрэгжилтийн талаар танилцуулга бэлтгэж танилцууллаа.

“Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”, “Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл”-д дэлгэрэнгүй санал боловсруулжээ.

Улсын Дээд шүүхийн Шүүхийн практик судлалын хэлтсийн шинжээчдэд зориулсан судалгаа, шинжилгээний ажил, үйлчилгээндээ хэрэглэх SPSS мэргэжлийн тооцоолол, шинжилгээний программ хангамжийн хэрэглээний сургалт явуулсан бөгөөд эрүү, иргэний шинжээч тус бүрт SPSS программын танилцуулга,



шүүхийн шийдвэрээс хэрхэн мэдээлэл цуглуулж, өгөгдөл болгон кодлож, уг программд шивж оруулах гарын авлага, тус программд ажиллах эх хэвийг бэлтгэн өгч дадлагажуулж байна.

“Монголын төр эрх зүй” сэтгүүлийн 2016 оны I, II, III дугаарыг, “Монгол Улсын Дээд шүүхийн мэдээлэл” сэтгүүлийн 2015 оны II, III, IV дугаарыг гаргаж, нийтийн хүртээл болгожээ.

Монгол Улсын хуулиуд, Монгол Улсын нэгдэн орсон болон хоёр талын гэрээ хэлэлцээр, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Ерөнхий шүүгчийн захирамж, эрүү, иргэний болон захиргааны хэргийн танхимын болон тус хэлтсээс гаргасан тойм зөвлөмж, шүүн таслах ажлын практик ач холбогдол бүхий хяналтын шатны эрүү, иргэний болон захиргаа, нийт шүүгчдийн хуралдааны тогтоолуудаар Улсын Дээд шүүхийн мэдээллийн “**Нэгдсэн сан**”-г баяжуулж байна.

Мөн Улсын Их Хурлын тогтоол **112**, Төрийн мэдээлэл сэтгүүлийн **44** дугаар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг **18**, Монгол Улсын хууль **244**, Үндсэн хуулийн цэцийн тогтоол, дүгнэлт **14** тус бүр хүлээн авч, нэгдсэн санд болон Legalsystem.mn хуулийн мэдээллийн санд тус тус оруулжээ.

Түүнчлэн 2015 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар Монгол Улсын хууль **244** хүлээн авч, шинээр батлагдсан 30 хууль, нэмэлт өөрчлөлт орсон **188** хууль, зарим зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцогдсон **6** хууль, хүчингүй болсон **20** хуулийн эх хууль болон “**Төрийн мэдээлэл**” сэтгүүлийн хувьд тухай бүрт нь ажилбар хийж, нэгдсэн сан дахь хуулиудад өөрчлөлтийг давхар оруулсан байна.

Мөн 1911-2015 онд батлагдан гарсан эрүү, иргэний болон захиргааны материаллаг болон процессын хууль тогтоомжийн цахим санг Үндсэн хууль болон органик хууль **35**, материаллаг **16**, процессын **12** хуулиар бусад холбогдох эрх зүйн **50** актаар тус тус бүрдүүлж, шүүхтэй холбоотой хууль тогтоомжуудыг архиваас судлах, хуулбарлах, хянах, байршуулах ажлыг гүйцэтгэлээ.

Улсын Дээд шүүхийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Монгол Улсад шүүх байгуулагдсаны 105 жил, Улсын Дээд шүүх байгуулагдсаны 90 жилийн ойг угтаж “**Монголын шүүх-I**”, “**Монголын шүүх-II**”, “**Монголын шүүх-III**” ботиудыг боловсруулан дуусгаж, хэвлүүлж нийтийн хүртээл болгосон байна.

### 3. Шүүхийн санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр:

Улсын Дээд шүүхийн 2016 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тус хэлтэс нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланг холбогдох





байгууллагуудад хуулийн хугацаанд хүргүүлэх, санал дүгнэлт гаргуулах, төсвийн төлөвлөлтийг оновчтой зөв тооцон боловсруулах, батлуулах, хуваарилах, батлагдсан төсвийг хууль, тогтоомжийн дагуу зөв зохистой зарцуулах, төсөв санхүү болон бусад холбогдох хууль тогтоомж, түүний хэрэгжилтийг хангах, шүүхийн санхүүгийн үйл ажиллагааг НББОУС-ын дагуу хөтлөх зэрэг үндсэн чиг үүргийн ажлуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллалаа.

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулиар Улсын Дээд шүүхийн төсвийн багц **3.3** тэрбум төгрөгөөр батлагдсан боловч дээрх хуулинд нэмэлт өөрчлөлт орсноор **3.4** тэрбум төгрөг болж, төсвийг хяналтын шатны шүүхийн хэвийн үйл ажиллагааг хангахад зарцуулсан байна.

2016 онд улсын төвлөрсөн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр **3.4** тэрбум төгрөг авснаас **3.2** тэрбум төгрөгийг зарлага гаргаж, **95%**-ийн төсвийн гүйцэтгэлтэй гарчээ.

Үндэсний Аудитын газраас Улсын Дээд шүүхийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, “Улсын Дээд шүүхийн 2015 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлан УСНББҮУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн шударга илэрхийлэгдсэн байна” гэж дүгнэн, “Зөрчилгүй санал дүгнэлт” гаргаж, тус хэлтсийн ажлыг дүгнэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу Улсын Дээд шүүхийн 2017 оны урсгал төсвийг **7.7** тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын төсвийг **20.9** тэрбум төгрөг буюу нийт **28.6** тэрбум төгрөгөөр төлөвлөж, хязгаарын санал, төсвийн саналыг боловсруулж холбогдох газруудад хүргүүлсэн боловч улс орны эдийн засгийн хүндрэлтэй байдлаас 2017 оны урсгал төсөв **4.0** тэрбум төгрөгөөр батлагдлаа.

Батлагдсан төсвийг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.2 дахь заалтад заасны дагуу хуваарийн төсөл боловсруулан Сангийн яаманд хүргүүлж, Fiscal програмд оруулах, шүүхийн 2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг e-procurement.mn сайт дээр байршуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шүүхийн хэвийн ажиллагааг хангахад зарцуулсан бөгөөд сургалт семинар зохион байгуулах, зочин төлөөлөгч хүлээн авах, томилолтоор ажиллах зэрэг үйл



ажиллагааны зардалд **171.1** сая төгрөг, шүүхийн ахмад ажилчдыг хүлээн авах, шагнал урамшуулал, тэтгэмжийн зардалд **129.8** сая төгрөгийн зардал гаргажээ.

Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журмын 7.1.3-т “**шүүгч, ажилтныг шаардлагатай тавилга, тоног төхөөрмж, техник хэрэгслээр хангах**” гэж заасны дагуу батлагдсан төсвийн хүрээнд Төрийн өмч, бодлого зохицуулалтын газраас зохих зөвшөөрөл авснаар **67.1** сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж авч үндсэн хөрөнгөнд бүртгэж, ашиглалтад хүлээлгэн өгсөн байна.

Шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах, хяналтын шатны шүүн таслах ажлыг таниулах, сурталчлах, хэргийн оролцогч, иргэд, хуулийн этгээдэд түргэн шуурхай мэдээлэл хүргэх зорилгоор Улсын Дээд шүүхийн цахим хуудсанд модуль нэмэх, вирусны програм суулгах ажлыг **4.9** сая төгрөгөөр, хяналтын шатны шүүхийн 2015 оны тайлан болон Иргэний хуулийн тайлбар, “Монголын шүүх” боть ном хэвлүүлэх зэрэг ажлуудыг **33.6** сая төгрөгөөр санхүүжүүлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 72, 73 дугаар зүйлд заасны дагуу “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллого” болохтой холбогдуулан Тамгын газрын даргын 2016 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн А/16 дугаар тушаалаар хөрөнгийн тооллого зохион байгуулах, хэрэгжүүлэх комисс байгуулагдан бүтэн жилийн хөрөнгийн тооллогыг хийж, нэгдсэн дүнг тайлагнаж, Төрийн өмчийн тооллогын бэлтгэл ажлыг бүрэн хангасан байна.

Мөн “Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн мэдээллийн систем”-ийн програм хангамжинд Улсын Дээд шүүхийн 2015 оны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдэл, холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь багтаан оруулжээ.

Дээрх өмч хөрөнгийн тооллого болон урсгал засварын ажлыг эхлэхтэй холбогдуулж, 2016 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Улсын Дээд шүүхийн байрны цахилгааны щитний трансформатор, агуулахын өрөөний дээвэр, дотоод засвар, шүүх хуралдааны танхимын засвар, зөөврийн индэр, шилэн хаалт хийх болон жижиг засварын ажлуудыг өөрсдийн дотоод нөөцөд тулгуурлаж хийж гүйцэтгэлээ.

Түүнчлэн авто тээврийн хэрэгслүүдийн хэвийн ажиллагааг хангах урсгал засвар хийх, эвдрэл гэмтлүүдийг засварлах, даатгал, оношлогоо зэрэг ажилд **23.6** сая төгрөг, шүүгчдийн даатгал, шүүхийн байрны ашиглалтын зардал болон бусад ажилд **142.4** сая төгрөгийг зарцуулсан байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй “Emerald” програмын баазын шинэчлэлтийг хийх ажлыг зохион байгуулж, шинэчилснээр програмыг хэрэглээнд бүрэн оруулж, ашиглаж эхэллээ. Ингэснээр хөрөнгө болон харилцагчын кодчилал, хөрөнгийн эдийн засгийн ангилал тодорхой болж програмын хэрэглээ хялбаршиж



ажиллагаа хөнгөвчилөгдөх давуу талуудтай болсноор ашиглалт сайжрах боломжтой боллоо.

Мөн шүүгч ажилтнуудыг шаардлагатай бичиг хэрэг, хангамжийн материал, цэвэрлэгээ үйлчилгээний хэрэгслээр хангах болон бараа материал, шатахууны зардалд **106.6** сая төгрөгийн зарлага гаргаж, 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ерөнхий ажил болон Улсын Дээд шүүхийн 90 жилийн ойн хүрээнд хийгдэх төлөвлөгөөт ажлуудыг батлагдсан төсвийн хэмжээнд санхүүжүүлж, дэмжин ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) болон Улсын Дээд шүүхийн [www.supremecourt.mn](http://www.supremecourt.mn) сайт дахь Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны батлагдсан төсөв, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, бүтэн жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш хэмжээтэй зардал зэрэг холбогдох шаардлагатай мэдээ, мэдээллүүдийг цаг тухай бүрт нь хуулийн хугацаанд оруулах болон тайлангуудыг холбогдох газар, хэлтсүүдэд хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллажээ.

Үүнтэй холбогдуулан Үндэсний Аудитын газраас “Шилэн дансны хууль”-ийн хэрэгжилтийг шалгах ажлын хүрээнд хагас жил тутам шалгалт хийсэн бөгөөд “Зөрчилгүй” гарсан байна.

#### 4. Шүүхийн зохион байгуулалтын чиглэлээр:

Тус хэлтэс нь шүүн таслах ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах нөхцөлийг хангах ажлыг зохион байгуулан, шүүх хуралдааны танхим, техник, зохион байгуулалтын бэлтгэлийг хангах, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийн төсөл боловсруулах, ёсчлуулах, тэдгээрийг [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) болон [www.supremecourt.mn](http://www.supremecourt.mn) цахим хуудсанд байршуулах, шүүх хуралдааны тэмдэглэл хөтөлж, шүүх хуралдааныг дуу болон дүрс бичлэгээр баталгаажуулах, шүүн таслах ажиллагааны хагас, бүтэн жилийн мэдээ тайлан гаргах ажлыг зохион байгуулах зэрэг хуульд заасан бусад чиг үүргийг гүйцэтгэжээ.

Танхимын тэргүүний туслах, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын ажлын зохион байгуулалт, хэргийн хөдөлгөөний аргачлал, албан хэрэг хөтлөлт, цахим санд шүүхийн шийдвэр нийтлэх журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Улсын Дээд шүүхийн хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэгдсэн эрүүгийн **337** иргэний **1469**, захиргааны **444** хэргийн тогтоол, шүүх хуралдааны зар **2512**-г цахим хуудсанд байршууллаа.



**2014-2015** онд Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн эрүү, иргэн, захиргааны хэргийн тогтоолыг [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) сайтад бүрэн байршуулжээ.

Мөн **2015** оны **10** дугаар сарын **01**-ний өдөр хүлээн авсан Улсын Дээд шүүхийн шинэ вэб сайтад “**Хяналтын шатны шүүх хуралдааны зар, тойм, статистик мэдээ**”-г тус тус тогтмол байршуулж байна.

Тайлангийн хугацаанд Тахарын алба /хуучнаар/, Цагдаагийн байгууллагаас шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангаж шүүх хуралдааны журам сахиулан ажиллах хугацаанд **Г.Буяндорж, Г.Цогт, Б.Маралмаа, Л.Гансүх** нарт холбогдох эрүүгийн хэрэг, намуудын бүртгэл, хүсэлт зэргийг шийдвэрлэсэн онцлох шүүх хуралдаануудыг шийдвэрлэсэн байна.

Мөн хугацаанд тус хэлтэс нь иргэн, албан тушаалтан, байгууллагаас ирсэн нийт **109** өргөдөл, гомдол, хүсэлтийг зохих журмын дагуу хүлээн авч, судлан холбогдох албан тушаалтанд танилцуулан, хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, хариуг хүргүүлсэн байна.

Шүүхийн захиргааны тухай хуулийн **26** дугаар зүйлийн **26.2**-т заасан чиг үүргийн дагуу /шүүгчийн туслахууд/ шүүгчид хуваарилагдсан хэрэг, маргааны талаарх бичиг баримтын бүрдлийг судалж, хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан шүүгчээс даалгасан ажиллагааг гүйцэтгэх, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, шаардлагатай хууль тогтоомжийн талаар мэдээлэл бэлтгэх, хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангах зэрэг ажлуудыг гүйцэтгэжээ.

Тайлангийн хугацаанд шүүгчийн туслахууд эрүү, иргэн, захиргааны хэргийн нийт **2221** тогтоол, захирамжийн, **253** албан бичиг, өргөдөл, гомдол, хүсэлтийн төсөл боловсруулан, шүүгчид танилцуулан, ёсчлуулсан байна.

Шүүхийн захиргааны тухай хуулийн **27** дугаар зүйлийн **27.2**-т заасан чиг үүргийн дагуу /шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нар/ шүүх хуралдааны техник, зохион байгуулалтын бэлтгэлийг хангаж эрүү, иргэн, захиргааны хэргийн нийт **2512** шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөж, шүүх хуралдааныг дуу болон дүрс бичлэгээр баталгаажуулж, шүүх хуралдааны тэмдэглэлийг хэргийн оролцогчдод хуульд заасан хугацаанд танилцуулан, шүүгчээр баталгаажуулж, хэргийн материалд хавсаргажээ.

## 5. Шүүхийн хэвлэл мэдээллийн чиглэлээр:

Тайлангийн хугацаанд Улсын Дээд шүүхийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс Улсын Дээд шүүхийн шүүн таслах болон бусад үйл ажиллагааны



талаар өдөр тутмын сонинд **77**, телевизэд **174**, радиод **57**, вэб сайтуудад **412** мэдээ, мэдээлэл бэлтгэн нийтлүүлж нэвтрүүлжээ.

### **Телевизийн нэвтрүүлгийн хувьд:**

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь** 2016 оны 2 дугаар сарын 25-ны өдөр **МҮОНТ**-ийн “**Эрх зүйн хөтөч**” нэвтрүүлэгт оролцож, “**Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль**” сэдвээр;

Улсын Дээд шүүхийн шүүгч асан, хуульч **А.Доржготов** 2016 оны 03 дугаар сарын 10-ны өдөр **МҮОНТ**-ийн “**Эрх зүйн хөтөч**” нэвтрүүлэгт оролцож, “**Өв залгамжлал**” сэдвээр;

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч **Н.Батзориг** 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдөр **МҮОНТ**-ийн “**Эрх зүйн хөтөч**” нэвтрүүлэгт оролцож, “**Хөдөлмөрийн маргаан**” сэдвээр;

Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч **Д.Даваасүрэн** 2016 оны 5 дугаар сард “**Эрх зүйн хөтөч**” нэвтрүүлэгт оролцож, “**Гэр бүлийн маргаан**” сэдвээр;

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь** 2016 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр **МҮОНТ**-ийн “**Эрх зүйн хөтөч**” нэвтрүүлэгт оролцож, “**Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль**” сэдвээр тус тус ярилцлага өгчээ.

Мөн 2016 оны 02 дугаар сарын 11-ний өдөр “**Цахим гэмт хэрэг**” сэдвээр;

2016 оны 3 дугаар сарын 31-ний өдөр “**Хөдөлмөрийн маргаан**” сэдвээр;

2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр “**Гэр бүлийн маргаан**” сэдвээр;

2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр “**Өмчлөх эрхийн маргаан**” сэдвээр тус тус зохиомжит нэвтрүүлэг хийсэн байна.

Түүнчлэн 2016 оны 10 дугаар сарын 13-ны өдөр **МҮОНТ**-ийн “**Эрх зүйн хөтөч**” нэвтрүүлгээр Нийслэлийн Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн шүүхүүдээс сурвалжилсан нэвтрүүлэг, 2016 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс нэг өдрийн сурвалжилсан нэвтрүүлэг бэлдэх ажлыг зохион байгуулж, хамтран оролцсон байна.

### **Сонин, сайтын нийтлэлийн хувьд:**

Шүүхийн талаар бодит ойлголт олон нийтэд хүргэх үүднээс шүүхийн шинэчлэл болон шүүх, шүүгчийн үйл ажиллагаа, шүүхийн шийдвэртэй холбоотой давхардсан тоогоор нийт **42** нийтлэл, ярилцлага, сурвалжлагыг өөрсдөө буюу сэтгүүлчдээр бэлдүүлэн сонин, сайтад нийтлүүлжээ.




## 6. Ерөнхий шүүгчийн ажлын алба:

Тус алба нь тайлангийн хугацаанд нийт **56** албан бичиг, **70** өргөдөл, гомдол хүлээн авч, хуулийн хугацаанд нь хариу өгчээ.

Ерөнхий шүүгчид гаргасан гомдлыг үндэслэн Ерөнхий шүүгчийн ажлын алба эрүүгийн **23**, иргэний **72**, захиргааны **34**, нийт **129** хэрэг хүлээн авч, Ерөнхий шүүгчид танилцуулж, хариу өгсөн байна.

Өмнөх онтой харьцуулбал:



Ажлын албаны дарга, бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан шинжээчийг байлцуулан хэргийн оролцогчид болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгч **98** иргэнийг сар бүрийн **4** дүгээр **7** хоногийн **пүрэв** гарагт болон хөдөө орон нутгаас ирсэн иргэдийг тухайн өдөрт нь хүлээн авч уулзан санал хүсэлтийг нь сонсож, тэдний санал, хүсэлтийг Ерөнхий шүүгчид тухай бүрт нь танилцуулж, зохих хариуг өгчээ.

Ерөнхий шүүгчид хандаж гаргасан гомдлын дагуу эрүү, иргэний болон захиргааны хэргийг хянах явцад шүүх, шүүгчдийн болон захиргааны ажилтнуудын гаргасан алдаа, зөрчилд анхаарах асуудлаар тусгайлан бүртгэл хөтөлж, шүүгч, ажилтанд энэ талаар мэдэгдэж, зөвлөмж өгч ажиллажээ.

Улсын Дээд шүүхэд 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2016 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хооронд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн цагаатгалын үнэмлэх олгох талаар хэлмэгдэгчдийн төрөл садан болон Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссуудаар дамжуулан **37** өргөдөл,



хүсэлтийг хүлээн авч нийтдээ **31** үнэмлэх олгосноос **16** үнэмлэх шинээр, **15** үнэмлэх нөхөн олгожээ.

## 7. Шүүхийн гадаад арга хэмжээний чиглэлээр:

Шүүхийн гадаад харилцаа жилээс жилд өргөжин тэлж шүүгч, ажилтнууд тив дэлхийн болон олон улсын, бүсийн чуулга уулзалт, эрдэм шинжилгээний бага хуралд оролцож шүүн таслах ажиллагааны талаарх туршлага судлах ажил өргөжсөөр байна. Тухайлбал,

Шүүгч **Х.Батсүрэн**, **Г.Алтанчимэг**, **Д.Ганзориг**, **Ц.Сумъяа**, Санхүү хангамж үйлчилгээний хэлтсийн дарга **Н.Булгамаа**, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Д.Тулга** нар Испанийн Вант Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч ноён **Карлос Д.Серраногийн** урилгаар тус улсын Мадрид, Барселон хотуудад 2016 оны 01 дүгээр сарын 23-31-ний өдрүүдэд “**Монгол Улсын Шүүхийн шүүгч, ажилтан нарт зориулсан сургалт**”-д;

Шүүгч **Д.Мөнхтуяа** Монгол Улсын Дээд шүүх, Шүүхийн Ерөнхий зөвлөл, АНУ-ын элчин сайдын яамнаас хамтран АНУ-ын Вашингтон ДиСи хотноо 2016 оны 5 дугаар сарын 22-31-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “**Олон Улсын эмэгтэй шүүгч нарын чуулга уулзалт**”-д;

Шүүгч **Ч.Тунгалаг** Бүгд Найрамдах Польш Улсад 2016 оны 06 дугаар сарын 4-15 өдрүүдэд зохион байгуулагдсан тус улсын “**Захиргааны хэргийн шүүхэд туршлага судлах сургалт**” сэдэвт чуулга уулзалтад;

Шүүгч **Б.Цогт**, **П.Соёл-Эрдэнэ**, **Д.Цолмон**, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Д.Тулга** болон анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч нарын нийт 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр БНСУ-ын Дээд шүүх, Үндэсний Шүүхийн Захиргаанаас тус улсын Сөүл хотноо 2016 оны 8 дугаар сарын 7-18-ны өдрүүдэд зохион байгуулсан “**Сонгуулийн маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх нь**” сэдэвт сургалтад;

Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь**, шүүгч **Б.Батцэрэн**, **Б.Ундрах**, **Г.Цагаанцоож**, Санхүү хангамж үйлчилгээний хэлтсийн ахлах шинжээч **С.Баасанцэрэн** нар Испанийн Вант Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч ноён **Карлос Д.Серраногийн** урилгаар тус улсын Мадрид, Барселон хотуудад 2016 оны 10 дугаар сарын 03-07-ны өдрүүдэд “**Монгол шүүхийн шүүгч, ажилтан нарт зориулсан 2 дугаар ээлжийн сургалт**”-д;

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч **А.Мөнхзул**, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Д.Тулга** нар БНЭУ-ийн Лакноу хотноо 2016 оны 11 дүгээр



сарын 4-16-ны өдрүүдэд зохион байгуулсан “**Дэлхийн Ерөнхий шүүгч нарын 17 дугаар бага хурал**” сэдэвт олон улсын бага хурал, сургалтад тус тус оролцжээ.

**Гадаад айлчлалын хүрээнд:**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн **Мьянмарын** Холбооны Бүгд Найрамдах улсад 2016 оны 06 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд хийсэн албан ёсны ажлын айлчлалын бүрэлдэхүүнд Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь**, Тамгын газрын дарга **Ж.Наранпүрэв** нар багтсан бөгөөд айлчлалын хүрээнд бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулжээ.

**Гадаад хамтын ажиллагааны хүрээнд:**

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч **Ц.Зориг**, БНСУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд ноён **У Сун**-ыг 2016 оны 5 дугаар сарын 13-ны өдөр хүлээн авч уулзаж хоёр орны шүүхийн хамтын ажиллагааны талаар харилцан санал солилцов.

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь**, Тамгын газрын дарга **Ж.Наранпүрэв**, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Д.Тулга** нар Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага /ЕАБХАБ/-ын элчин сайд, Ардчилсан Институт Хүний эрхийн газрын Сонгуулийн ажиглах хорооны тэргүүн хатагтай **Одри Франсис Гловер** болон Хуулийн Шинжээч **Марла Морри** нарыг 2016 оны 6 дугаар сарын 21-ний өдөр хүлээн авч, сонгуулийн хэрэг маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх процесс, ялангуяа улс төрийн намуудын бүртгэл, сонгуультай холбоотой маргааныг захиргааны хэргийн шүүх шийдвэрлэх, болон Сонгуулийн тухай болон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд орсон сонгуулийн эрх зүйн зохицуулалтын талаар төлөөлөгчдийн сонирхсон асуудлын талаар мэдээлэл өгөв.

Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга **Ж.Наранпүрэв**, Гадаад харилцаа хамтын ажиллагааны албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Д.Тулга**, Гэмт хэргийн тухай хууль тогтоомж, практик ажил хариуцсан шинжээч **А.Баярцэцэг** нар БНСУ-ын Хойд Кёнги Мужийн Барын холбооны Ерөнхийлөгч ноён **И Куан Бук** тэргүүтэй төлөөлөгч нарыг 2016 оны 7 дугаар сарын 4-ний өдөр хүлээн авч Монгол Улсын шүүхийн тогтолцоо болоод Улсын Дээд шүүхийн үйл ажиллагааны талаар товч танилцуулга хийж төлөөлөгч нарын сонирхсон асуултад хариулсан юм. Уулзалтад Улсын Дээд шүүх болон Монголын Өмгөөлөгчдийн холбооны дэд Ерөнхийлөгч **Ж.Батзоригт** болон холбогдох албаны бусад хүмүүс оролцлоо.





Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь**, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүн **О.Зандраа** нар Монгол Улсад албан ёсны айлчлал хийж буй БНХАУ-ын Шүүгчдийн коллежийн дарга, Шүүгчдийн коллежийн намын хорооны дарга, Дээд шатны шүүгч **Хуанг Ёнг Вэй** тэргүүтэй төлөөлөгчдийг 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдөр хүлээн авч Монгол Улсад шүүхийн эдийн засгийн хараат бус байдлыг хэрхэн хангадаг, шүүгчийн орон тоо, цалин хөлс, шүүхийн төсөв, шүүхийн үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал, зэрэг асуудлуудын талаар сонирхон асууж, харилцан ярилцав. Уулзалтын үеэр БНХАУ-ын Шүүгчдийн коллежийн дарга, шүүгч **Хуанг Ёнг Вэй** өнгөрсөн онд БНХАУ-ын Шүүгчдийн коллеж өргөтгөн шинэчлэгдсэн бөгөөд цаашид Монголын шүүхийн шүүгч нарыг өргөн бүрэлдэхүүнтэй сургалтанд хамруулахаа илэрхийлж, бүс нутгийн болоод орон нутгийн шүүхүүд цаашид хамтран ажиллах сонирхолтой байгааг илэрхийлсэн байна.

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь**, Тамгын газрын дарга **Ж.Наранпүрэв** нар БНХАУ-ын Хуульчдын нийгэмлэгийн дэд ерөнхийлөгч **Жан Сужун** тэргүүтэй төлөөлөгчдийг 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр хүлээн авч, уулзсан байна.

**Гадаад харилцаа хамтын ажиллагааны албаны бусад чиг үүргийн хүрээнд:**

Шүүхийн даалгаврыг хилийн чандад явуулах болон хилийн чанадаас хүлээн авах ажлыг зохион байгуулах хүрээнд БНСУ-аас **1**, Австри улсаас **1**, ХБНГУ-аас **2**, Турк улсаас **1**, АНУ-аас **1** нийт 6 шүүхийн даалгавар ирсэн бол БНСУ-д **7**, БНХАУ-д **2**, нийт 9 шүүхийн даалгавар явуулаад байгаагаас БНХАУ-аас **1** шүүхийн даалгаврын хариуг хүлээж байна.

Гадаад улс орны шүүхийн үйл ажиллагааны туршлага судалж, манай улс оронд нэвтрүүлж болох зүйлийг хэрэгжүүлэх талаар анхаарал хандуулан ажиллаж байна.

## 8. Дотоод аудитын алба:

Улсын Дээд шүүхийн Дотоод аудитын алба сүүлийн 3 жилд байгууллагын бүтцийн нэгжийн хувьд төлөвшиж, цаашид шүүхийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирох аудитын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхэд анхаарч ажиллаж байна. 2016 онд Дотоод аудитын алба нь байгууллагын оршин байгаа алдаа зөрчлийг тайлагнахаас илүүтэйгээр байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, гарч болох алдаанаас сэргийлэх, дотоод хяналтын сайжруулахад чиглэн ажиллалаа. Энэхүү зорилтыг хангахын тулд Төсвийн ерөнхийлөн захирагч



буюу Ерөнхий шүүгчийн баталсан “Эрсдэлд суурилсан Дотоод аудитын жилийн төлөвлөгөөг” боловсруулан батлуулж, төлөвлөгдсөн ажлуудыг хэрэгжүүлсэн байна.

Үндэсний аудитын газрын санхүүгийн тайлангийн аудитын бэлтгэл, шилэн дансны хэрэгжилт, төлөвлөгөөт болон удирдлагын шийдвэрээр тусгайлсан аудитыг хэрэгжүүлсэн. Мөн эрсдлийн удирдлага ба засаглалын бусад асуудлаар зөвлөмж өгч ажиллалаа. Аудитын зөвлөмжийн талаар үр нөлөөтэй хариу арга хэмжээ авсан эсэх талаар удирдлагад тогтмол тайлагнаж ажилласан байна. “Эрсдэлд суурилсан Дотоод аудитын төлөвлөгөө”-нд тусгагдсан 12 аудитын ажил, мөн Тамгын газрын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг сар тутам төлөвлөж ажилласан байна.

Тухайлбал, 2015 оны Санхүүгийн тайланд урьдчилсан аудит хийж, бэлтгэл хангахад зөвлөмж өгч, Үндэсний Аудитын газраас Улсын Дээд шүүхийн 2015 оны санхүүгийн жилийн эцсийн тайланд “**Зөрчилгүй**” гэсэн дүгнэлт гарсан байна.

Үндэсний Аудитын газартай аудит хийхтэй холбоотойгоор мэдээлэл солилцох, туршлага судлах хэлбэрээр хамтран ажиллажээ.

Шилэн дансны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор уг хуулийн 8 дугаар зүйлийн 2-т заасны дагуу дотоод хяналтыг зохион байгуулж холбогдох мэдээллийг <http://shilendans.gov.mn/> сайтад мэдээлэл хуулийн хугацаанд тогтмол тавигдаж хэвшсэн бөгөөд Үндэсний аудитын газраас 2016 оны 11 дүгээр сард Шилэн дансны мэдээлэл байршуулсан байдал болон дотоод аудитын алба хяналт тавьж байгаа байдалд шалгуур үзүүлэлт бүрээр аудит хийсэн бөгөөд эцсийн дүнгээр зөрчилгүй гэсэн дүгнэлт өгсөн байна.

Дотоод аудитын алба нь 2015 оны санхүүгийн баримтанд аудит хийх төлөвлөгөө боловсруулан, санхүүгийн ба нийцлийн аудитыг хийж, удирдлагад танилцуулан, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавин ажиллажээ.

Холбогдох хууль тогтоомжид орсон өөрчлөлт, цаг үеийн бусад асуудлаар тайлан зөвлөмж боловсруулан холбогдох нэгжүүдэд танилцуулан цаашид болзошгүй эрсдлээс сэргийлэхэд чиглэн ажилласан байна.

Шүүхийн цахим сан, мэдээллийн мониторингийн “Иргэн-2014” нэгдсэн систем болон “Захиргаа”-ны программд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрийг бүрэн оруулах үйл ажиллагаанд аудит хийж, Шүүхийн зохион байгуулалтын хэлтэстэй хамтран ажиллажээ.

Төрийн захиргааны албан хаагчдын болон үйлчилгээний ажилтнуудын 2016 оны хагас, бүтэн жилийн “Үр дүнгийн гэрээ”-ний төсөл биелэлт, илтгэх хуудсанд



нийцлийн аудит хийж үнэлэлт дүгнэлт гарган ажлын тайланг тамгын газрын даргад хүргүүлж ажиллалаа.

Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага болон Монголын Дотоод аудиторчуудын хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан “Дотоод аудитын сургалт”-нд албаны ажилтнууд бүрэн хамрагдаж амжилттай дүн үзүүлэн сертификат гэрчилгээ авчээ.

Мөн 2015 онд хийсэн нийцлийн аудитын зөвлөмжийн биелэлтэнд мониторинг хийж удирдлагад танилцуулан ажиллажээ.

## 9. Шүүхийн сургалт, семинарын чиглэлээр:

Улсын Дээд шүүхийн шүүгч, ажилтнууд 2016 онд дараах сургалт, семинарыг зохион байгуулж, оролцлоо. Үүнд:

### Эрүүгийн хэргийн танхим

Танхимын тэргүүн **Т.Уранцэцэг** Улсын Дээд шүүхээс 2016 оны 2 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд анхан болон давж заалдах шатны нийт шүүхүүдийн Ерөнхий шүүгч нарт зориулсан “**Шүүн таслах ажиллагаа, шүүхийн шийдвэрийн талаарх практик**” сэдэвт сургалт-уулзалт, ярилцлагад “Хяналтын шатны шүүхээр 2015 онд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн алдаа, зөрчлийн тойм” сэдвээр;

Шүүгч **Б.Бат-Эрдэнэ** “Гэмт хэргийн бүрэлдэхүүний онол, практикын асуудал”, сэдвээр;

Шүүгч **Б.Батцэрэн** “Шинээр батлагдсан Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль” сэдвээр;

Шүүгч **Д.Ганзориг** “Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг” сэдвээр;

Шүүгч **Ч.Хосбаяр** “Олон Улсын гэрээ, конвенцийг шүүх хуулийн практикт хэрэглэх” сэдвээр;

Шүүгч **Б.Цогт** “Өршөөл үзүүлэх тухай хуулийг шүүхийн практикт хэрэглэх” сэдвээр;

Шүүгч **Д.Эрдэнэбалсүрэн** “Аргагүй хамгаалалт” сэдвээр тус тус сургалт зохион байгуулсан байна.

Шүүгч **Б.Батцэрэн** 2016 оны 3 дугаар сард шинээр томилогдсон шүүгч нарт “Эрүүгийн процесс ажиллагаанд хүний эрхийг хамгаалах нь”, “Шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал”, “Мэтгэлцэх зарчим” зэрэг сэдвээр;

2016 оны 11 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд Улсын Дээд шүүхийн Тамгын газраас Монголын Хуульчдын холбоотой хамтран зохион байгуулсан шүүгчийн туслах, шүүхийн захиргааны ажилтнуудад зориулсан кредит цаг олгох сургалтанд



**“Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг” “Эрүүгийн хууль” “Зөрчлийн тухай хууль”**

сэдвээр тус тус хичээл заажээ.

Эрүүгийн хэргийн танхим Шүүхийн Ерөнхий зөвлөлтэй хамтран 2016 оны 4 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд шүүхийн сургалтын "Баяндөхөм төв"-д эрүүгийн эрх зүйн сургагч багш нарын сургалтыг зохион байгуулж, сургалтын хөтөлбөр боловсруулж, шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 4, 5, 6 дугаар бүлгийн талаар хичээл заасан байна.

Танхимын тэргүүн **Т.Уранцэцэг** 2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан “Шүүгчийн ёс зүй ба хариуцлага” сэдэвт хэлэлцүүлэгт;

Шүүгч **Д.Ганзориг, Ч.Хосбаяр** нар 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Хууль зүйн яам, Тахарын ерөнхий газар, Нээлттэй нийгэм форумын хамтран зохион байгуулсан “Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” сэдэвт хэлэлцүүлэгт тус тус оролцлоо.

Шүүгч **Ч.Хосбаяр** 2016 оны 3 дугаар сарын 31, 4 дүгээр сарын 01-ний өдрүүдэд Хууль зүйн яамнаас зохион байгуулсан “Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн үзэл баримтлал” сургалт, Монголын Хуульчдын холбоо, Олон Улсын Улаан загалмайн хороо, Монголын Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран зохион байгуулсан “Хүчирхийлэл, гэмт халдлагын үед олон улсын хүмүүнлэг, хүний эрхийн эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх нь” сэдэвт;

Шүүгч **Б.Батцэрэн, Д.Ганзориг, Ч.Хосбаяр, Б.Цогт, Д.Эрдэнэбалсүрэн** нар 2016 оны 09 дүгээр сарын 26, 27-ны өдрүүдэд Шүүхийн ерөнхий зөвлөл, ХБНГУ-ын Ханнс-Зайдель сангийн “Эрх зүйн боловсрол академи” хамтран зохион байгуулсан эрүүгийн эрх зүйн шүүгч-багш нарын;

Танхимын тэргүүний туслах-Ахлах шинжээч **Ц.Батзаяа**, шүүгчийн туслах-шинжээч **Б.Володя, С.Золбоо, Б.Наранжаргал, Н.Нямдаваа, Б.Содгэрэл, Г.Ууганбаатар, Ө.Учрал**, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга-мэргэжилтэн **Т.Өлзийтүвшин** нар 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдөр “**Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системийг хэрэгжүүлэх**” ажлын хэсгээс зохион байгуулсан сургалтанд тус тус хамрагджээ.

Танхимын тэргүүн **Т.Уранцэцэг** 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Төрийн ордонд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл”-ийн анхдугаар хуралд оролцжээ.

**Иргэний хэргийн танхим**



Танхимын тэргүүн **Х.Сонинбаяр** 2016 оны 02 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд Улсын Дээд шүүхээс зохион байгуулсан “**Шүүн таслах ажиллагаа, шүүхийн шийдвэрийн талаарх практик**” сэдэвт сургалт-уулзалт ярилцлагад “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар 2015 онд шийдвэрлэгдсэн хэргийн тойм, судалгаа, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны өнөөгийн байдал” сэдвээр;

Шүүгч **Г.Алтанчимэг** “Нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлийг зөв тогтоох шүүгчийн ажиллагааны тухай” сэдвээр;

Шүүгч **Ц.Амарсайхан** “Эрх зүйн маргаантай харилцааг зөв тогтоож, хуулийн холбогдох зохицуулалтыг тайлбарлан хэрэглэх тухай”, сэдвээр;

Шүүгч **П.Золзаяа** “Гэрээний эрх зүйн маргаан хууль хэрэглээ болон гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахад анхаарах асуудлууд” сэдвээр;

Шүүгч **Б.Ундрах** “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан шүүгчийн хийх зарим ажиллагааны тухай”, сэдвээр;

Шүүгч **Г.Цагаанцоож** “Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар 2015 онд хянан шийдвэрлэсэн хэргийн алдаа, зөрчлийн тойм судалгаа, анхаарах зарим асуудал” сэдвээр сургалт явуулж,

Шүүгч **Х.Эрдэнэсүвд** “Сонгуулийн тухай хууль”-ийн талаар мэдээлэл хийжээ.

Шүүгч **Д.Цолмон** 2016 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Иргэний хэргийн танхимаас зохион байгуулсан “Иргэний хэргийн шүүн таслах ажиллагааны практик” уулзалт-ярилцлага”-ын хүрээнд Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүгч нартай хийсэн сургалт-ярилцлагад Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар 2016 оны 1 дүгээр улиралд хянан шийдвэрлэсэн хэргийн алдаа, зөрчлийн тойм судалгааг гаргаж, анхаарах зарим асуудлын талаар хэлэлцүүлсэн байна.

Танхимын тэргүүн **Х.Сонинбаяр**, шүүгч **Г.Алтанчимэг**, **Ц.Амарсайхан**, **П.Золзаяа**, **Б.Ундрах**, **Г.Цагаанцоож**, **Д.Цолмон**, **Х.Эрдэнэсүвд** нар 2016 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Иргэний хэргийн танхимаас зохион байгуулсан “**Иргэний хэргийн шүүн таслах ажиллагааны практик**” уулзалт-ярилцлагын хүрээнд Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүгч нартай,

2016 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нартай сургалт-ярилцлага хийжээ.

Шүүгч **Ц.Амарсайхан**, **П.Золзаяа** нар 2016 оны 3, 4, 5 сард Монголын Өмгөөлөгчдийн холбооноос зохион байгуулсан уулзалт-ярилцлагын хүрээнд



“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримт гаргах, үнэлэх, бүрдүүлэх” сэдвээр;

Шүүгч **П.Золзаяа** 2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нарт **“Шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зохицуулалт”** сэдвээр;

2016 оны 5 дугаар сарын 24-ний өдөр Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчээр шинээр томилогдсон шүүгч нарт **“Эвлэрүүлэн зуучлал”**-ын сэдвээр тус тус сургалт явуулсан байна.

Танхимын тэргүүн **Х.Сонинбаяр**, шүүгч **Г.Алтанчимэг**, **Ц.Амарсайхан**, **П.Золзаяа**, **Б.Ундрах**, **Г.Цагаанцоож**, **Д.Цолмон**, **Х.Эрдэнэсүвд** нар 2016 оны 6 дугаар сарын 06-10-ны өдрүүдэд Улсын Дээд шүүх болон Шүүхийн Ерөнхий зөвлөл, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн хамтран зохион байгуулсан “Үүргийн гүйцэтгэлийг хангах арга ба Иргэний хуулийн хэрэглээ, шүүхийн шийдвэр боловсруулах арга зүй” сэдэвт сургалтад;

Шүүгч **Д.Цолмон** Хууль зүйн яамнаас зохион байгуулсан “Дампуурлын тухай хуулийг шинэчилсэн найруулга” сэдэвт уулзалтад;

Шүүгч **Г.Цагаанцоож** Хууль зүйн яамнаас зохион байгуулсан “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг шинэчилсэн найруулга”-ын ажлын хэсгийн уулзалт, сургалтад;

Шүүгч **Г.Алтанчимэг**, **Б.Ундрах** нар 11 дүгээр сарын 30-наас 12 дугаар сарын 2-ны өдрүүдэд Шүүхийн ерөнхий зөвлөл, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны хооронд байгуулсан “Худалдааны эрх зүйн чиглэлээр Монгол Улсын шүүгчдийг сургах хөтөлбөр II шат, Өмнөх үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн асуудлаарх харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу “Худалдааны эрх зүйн сургагч багш бэлтгэх” сургалтад тус тус хамрагджээ.

Мөн 2016 оны 11 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд Улсын Дээд шүүхийн Тамгын газар, Монголын Хуульчдын холбоотой хамтран зохион байгуулсан шүүгчийн туслах, шүүхийн захиргааны ажилтнуудад зориулсан кредит цаг олгох сургалтанд;

Шүүгч **П.Золзаяа** “Хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгох зохицуулалтын хэрэглээ”, “Худалдах, худалдан авах гэрээний эрх зүйн зохицуулалт” сэдвээр;



Шүүгч **Г.Цагаанцоож** “Хөдөлмөрийн хуулийн хэрэглээ, анхаарах асуудал” сэдвээр;

Шүүгч **Г.Алтанчимэг** “ИХШХША-ны эрх зүй: Хүсэлт гаргах, шийдвэрлэх, нотлох баримт гаргах, цуглуулах, бүрдүүлэх ажиллагаа” сэдвээр тус тус хичээл заажээ.

### **Захиргааны хэргийн танхим**

Танхимын тэргүүн **М.Батсуурь** Улсын Дээд шүүхээс 2016 оны 2 дугаар сарын 03-04-ны өдрүүдэд анхан болон давж заалдах шатны нийт шүүхүүдийн Ерөнхий шүүгч нарт зохион байгуулсан “**Шүүн таслах ажиллагаа, шүүхийн шийдвэрийн талаарх практик**” сэдэвт сургалт-уулзалт, ярилцлагад “Захиргааны хэргийн шүүхийн шүүн таслах ажиллагааны тойм, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны ерөнхий хуулийн үзэл баримтлал, шинэлэг зохицуулалт” сэдвээр,

Шүүгч **П.Соёл-Эрдэнэ** “Сонгуулийн тухай” хуулиар,

Шүүгч **Л.Атарцэцэг, Х.Батсүрэн, Ц.Сумъяа** нар “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны алдаа, зөрчлийн тойм” сэдвээр тус тус сургалт явуулсан байна.

Танхимын тэргүүн **М.Батсуурь** 2016 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүгч, хуульч ажилтнуудад “**Захиргааны шийдвэр гаргах ажиллагаа**” сэдвээр;

2016 оны 3 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд Зам, тээврийн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Сангийн яамны ажилтнуудад “**Захиргааны ерөнхий хуулийн танилцуулага**” сэдвээр;

2016 оны 3 дугаар сарын 22-ны өдөр Захиргааны хэргийн шүүхийн шинэ шүүгч нарт “**Шүүхийн шийдвэр боловсруулах арга зүй**” сэдвээр;

2016 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр “**Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлал**” /шинэчилсэн найруулга/ сэдвээр;

2016 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр MIU дээд сургуулийн багш оюутнуудад “**Орчин үеийн чөлөөт нийгэм дэх шүүхийн үүрэг**” сэдвээр;

2016 оны 5 дугаар сарын 13, 6 дугаар сарын 03, 12 дугаар сарын 16-ны өдөрүүдэд МӨХолбооны хуульч нарт “**Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлал**” сэдвээр;

2016 оны 5 дугаар сарын 19-20, 6 дугаар сарын 02-ны өдрүүдэд “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлал, шинэлэг зохицуулалт” сэдвээр;



2016 оны 11 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд Улсын Дээд шүүхийн Тамгын газраас Монголын Хуульчдын холбоотой хамтран зохион байгуулсан шүүгчийн туслах, шүүхийн захиргааны ажилтнуудад зориулсан кредит цаг олгох сургалтанд **“Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль” “Захиргааны ерөнхий хууль, хуулийн үзэл баримтлал”** сэдвээр;

Шүүгч **Л.Атарцэцэг** 2016 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан шинэ шүүгч нарт зориулсан сургалтанд **“Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа”** сэдвээр;

“Захиргааны хэргийн шүүх хуралдаан”, “Захиргааны хэргийн шүүх хууль тайлбарлан хэрэглэж байгаа байдал, анхааран зарим асуудал” сэдвээр;

Шүүгч **П.Соёл-Эрдэнэ** 2016 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүгч, ажилтнуудад зориулан **“Сонгуулийн тухай хууль”** сэдвээр;

2016 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр Төрийн албаны Зөвлөлийн албан хаагчдад;

2016 оны 10 дугаар сарын 14-ны өдөр УИХ-ын Тамгын газрын ажилчдад;

2016 оны 10 дугаар сарын 21-ны өдөр Монгол банкны ажилчдад;

2016 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Төрийн аудитын газарт;

2016 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн албан хаагчдад;

2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Төрийн бус байгууллагуудын ажилчдад **“Захиргааны Ерөнхий хууль”** сэдвээр;

Шүүгч **Х.Батсүрэн** 2016 оны 6 дугаар сарын 02-ны өдөр Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч нарт **“Шүүх нотлох зарчим ба нотлох ажиллагаа”** сэдвээр;

2016 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Хууль сахиулахын Удирдлагын академиас зохион байгуулсан **“Стратегийн дамжаа”** буюу хууль сахиулах байгууллагын удирдах албан тушаалтнуудад **“Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдэх хэрэг маргаан-дүн шинжилгээ”** сэдвээр;

Шүүгч **Д.Мөнхтуяа** 2016 оны 5 дугаар сард Захиргааны Ерөнхий хуулиар Монгол Банк, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аудитын газарт;

2016 оны 06 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд **“Захиргааны хэргийн шүүх хууль тайлбарлан хэрэглэж байгаа байдал, анхаарах зарим асуудал”** сэдвээр;

мөн өдрүүдэд хөдөө орон нутгийн шүүгч нарт **“Захиргааны хэргийн шүүх хууль тайлбарлан хэрэглэж байгаа байдал, анхаарах зарим асуудал”** сэдвээр;





2016 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Улсын Дээд шүүхийн Тамгын газраас Монголын Хуульчдын холбоотой хамтран зохион байгуулсан шүүгчийн туслах, шүүхийн захиргааны ажилтнуудад зориулсан кредит цаг олгох сургалтанд “Хуульчийн ёс зүй” сэдвээр тус тус хичээл заасан байна.

Шүүгч **Д.Мөнхтуяа** 2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан “Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь” сэдэвт;

2016 оны 11 дүгээр сарын 30-наас 12 дугаар сарын 02-ны өдрүүдэд IDLO шүүгч сургах төслийн сургагч багш бэлтгэх;

Шүүгч **Л.Атарцэцэг** 2016 оны 3 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд Захиргааны хэргийн шүүхийн сургагч багш нарын;

2016 оны 4 дүгээр сарын 13-28-ны өдрүүдэд БНХАУ-ын Ардын дээд шүүхийн шүүгчдийн коллежид сургалтад тус тус хамрагдлаа.

Шүүгч **Д.Мөнхтуяа** 2016 оны 02 дугаар сард Төрийн ордонд “Төрийн албаны тухай хууль”-ийн талаарх хэлэлцүүлэгт;

Шүүгч **П.Соёл-Эрдэнэ** 2016 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр “Өрсөлдөөний хуулийн өөрчлөлтийн ерөнхий чиглэл” хэлэлцүүлэгт тус тус оролцсон байна.

### Шүүхийн тамгын газар

Улсын Дээд шүүхийн Тамгын газар, Монголын Хуульчдын холбоотой хамтран 2016 оны 11 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд хуульчийн гэрчилгээ бүхий захиргааны ажилтнуудад “Худалдах, худалдан авах гэрээний эрх зүйн зохицуулалт”, “ИХШХША-ны эрх зүй: Хүсэлт гаргах, шийдвэрлэх, нотлох баримт гаргах, цуглуулах, бүрдүүлэх ажиллагаа”, “Хөдөлмөрийн хуулийн хэрэглээ, анхаарах асуудал”, “Хөдөлмөрийн хуулийн хэрэглээ, анхаарах асуудал”, “Хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгох зохицуулалтын хэрэглээ”, “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”, “Захиргааны ерөнхий хууль, хуулийн үзэл баримтлал”, “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг”, “Үндсэн хуулийн эрх зүй”, “Хуульчийн ёс зүй”, “Эрүүгийн хууль”, “Зөрчлийн тухай хууль”, “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”, “Захиргааны ерөнхий хууль, хуулийн үзэл баримтлал” сэдвээр 4 багц кредит цагийн;

Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч **Б.Батцэрэн**, Иргэний хэргийн танхимын шүүгч **Б.Ундрах**, Тамгын газрын дарга **Ж.Наранпүрэв** нар “Хуульчийн сонгон шалгаруулалт”-ын шалгалтанд орох



Тамгын газрын 12 захиргааны ажилтанд “Эрүүгийн эрх зүйн бодлого бодох аргачлал”, “Иргэний эрх зүйн бодлого бодох аргачлал”, “Захиргааны эрх зүйн бодлого бодох аргачлал” сэдвээр 6 цагийн сургалтыг тус тус зохион байгуулжээ.

Мөн Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн албан бичгийн дагуу 2016 оны 12 дугаар сард тус шүүхийн шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарт “Монгол хэлний хэл зүйн найруулага” сэдвээр сургалт зохион байгуулжээ.

### **Эрхэм шүүгч, ажилтнууд аа!**

2017 онд бид шүүхийн дээд байгууллагын хувьд шүүн таслах ажиллагааны талаарх Үндсэн хуулийн үзэл баримтлал, иргэд, нийгмийн хэрэгцээ шаардлага, дэлхийн жишиг, монголын туршлагыг харгалзан нэн хариуцлагатай, ажил хэрэгчээр уламжлал, шинэчлэлийг хослуулан ажиллах нь чухал байна.

Тиймээс бид өмнөө тавьсан зорилтоо амжилттайгаар гүйцэлдүүлэхэд Та бүхнийг идэвхи санаачлага, итгэл зүтгэл, үр бүтээл гарган ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Та бүхэндээ удахгүй болох Монгол Улсад орчин цагийн шүүх байгуулагдсаны 105, Монгол Улсын Дээд шүүх байгуулагдсаны 90 жилийн баярын мэнд дэвшүүлж, аз жаргал, эрүүл энхийг хүсэн ерөөе.

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ,  
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР**

*2016 оны 12 дугаар сарын 27-ны өдөр*